
ТӨРИЙН БАНКНЫ САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛ

Улаанбаатар хот
2023 он

- Төрийн банкны товч танилцуулга, онцлох үйл явдлууд
- Санхүүгийн үзүүлэлт
- Бизнес төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны товч танилцуулга

БАНКНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



Газар - 16

Хэлтэс - 20

Алба - 9

САЛБАР


Улаанбаатарын
нэгж - 83

Орон нутгийн
нэгж - 413



НИЙТ АЖИЛТНУУД

- Орон нутаг
- Төв
- Улаанбаатар нэгж




- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулж, хурлаар нэмж хувьцаа гарган олон нийтэд санал болгох тухай шийдвэрлэлээ.
- 2022 онд Олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийг Тогтвортой хөгжил, Дундаж давхаргад чиглэсэн бүтээгдэхүүнд бүрэн зарцууллаа.
- 2022 оны татварын дараах цэвэр ашгийн 50 хувиар ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн ба “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иар дамжуулан 2023.04.28-ны өдөр ногдол ашиг тараалаа.

- Cargill Financial Services International, Inc-аас гадаад худалдааг дэмжих хүрээнд 25 сая ам.долларын эх үүсвэрийг амжилттай татлаа.

- Цалингийн цахим зээлийг нийт ажилчиддаа нэвтрүүллээ.
- Харилцагчийн мэдээллийн төвийн 1800-1881-ийн хэмжээнд CRM системийг туршиж амжилттай нэвтрүүллээ. */Харилцагчийн удирдлагын систем буюу /CRM/ харилцагчийн санал хүсэлт бүртгээж, дамжуулах программ/*


Нийт актив /сая төгрөг/

Төрийн банк сүүлийн гурван жил зах, зээл эзлэлтээ нэмэгдүүлж нийт активаа дунджаар 8.1 хувиар нэмэгдүүлсэн.



Татварын дараах ашиг/алдагдал /сая төгрөг/


Төрийн банкны сүүлийн гурван жилийн дундаж цэвэр ашгийн өсөлт 71 хувь байгаа бол банкны салбарын цэвэр ашгийн өсөлт 63.9 хувьтай байна.



ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ


Нийт өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт /CAR/

Өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцааг тогтмол ханган ажиллахын зэрэгцээ, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг байнга давуулан биелүүлж ажилласан.



Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа /LIQ/

Монголбанкны шалгуур үзүүлэлтийг тогтмол ханган ажилласан төдийгүй бүлгийн дундажтай харьцуулсан үзүүлэлтүүд дунджаас дээгүүр үзүүлэлттэй байна.



- Төрийн банкны 2023 оны Бизнес төлөвлөгөө нь Стратегийн тэргүүлэх 3 чиглэлийн дагуу зорилтууд дэвшүүлсэн ба 2023 оны 6 дугаар сарын 30-ний байдлаар явцын гүйцэтгэл 66.4% байна.



Цахим шилжилт хийж, бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх:

- ✓ Хэрэглээний зээл цахимаар олгох программчлалыг хөгжүүлсэн, туршилтын шатанд явж байна.
- ✓ Банкны хэмжээнд эрхзүйн баримт бичгийг хянах, санал авах үйл ажиллагааг цахимжуулж, цаг хугацаа, цаасны зардал хэмнэх боломжтой боллоо.
- ✓ Киоск машинаар үзүүлэх үйлчилгээг нэмэгдүүлэн интернэт, кабелийн төлбөр, тээврийн хэрэгслийн торгууль төлөх, халамж лавлах, бүх төрлийн төлбөр дансаар төлөх боломжтой болсон.
- ✓ АТМ-р төлбөр тооцоо хийх хүртээмжийг нэмэгдүүлж ХХБ, Голомт банкны АТМ харилцан 100₮ боллоо. PCI-DSS онсайт аудитыг амжилттай хийлгэн, сертификатын эрхээ сунгалаа.
- ✓ Картын дугаарын аюулгүй байдлыг сайжрууллаа.
- ✓ Гялсбанкны идэвхтэй харилцагч 303.5 мянгад хүрлээ.

Банкны үйл ажиллагааг байгальд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, зохистой засаглалыг бэхжүүлэх чиглэлд хандуулах:

- ✓ Байгаль орчин, нийгэм засаглалын чиглэлийн үйл ажиллагааг өргөн цар хүрээнд хэрэгжүүлэх зорилгоор тогтвортой хөгжлийн албыг үүсгэн Тогтвортой хөгжлийн журмыг баталлаа.
- ✓ Банкны тасралтгүй үйл ажиллагааг хангаж ажиллах зорилгоор олон улсын банк хоорондын төлбөр тооцооны СВИФТ системээс гүйлгээг багцлах үйлчилгээ (Automated File Transfer) авдаг боллоо.
- ✓ Мөн мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны чанар, үр нөлөөг олон улсын жишигт хүргэх, сайн туршлагыг нэвтрүүлэх ажлын хүрээнд сэжигтэй гүйлгээг илрүүлэх тусгай хяналтын цогц программыг суурь бүртгэлийн NES системтэй уялдуулан Төрийн банкны үндсэн системд нэвтрүүлсэн.

Дундаж давхаргыг дэмжихэд чиглэсэн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх, хөгжүүлэх:

- ✓ Боловсролыг дэмжих зээл болон Өрх, гарааны бизнесийн зээлийн бүтээгдэхүүнийг харилцагчийн хэрэгцээнд тулгуурлан сайжрууллаа
- ✓ "Эрүүл иргэн" хугацаатай хадгаламжийн бүтээгдэхүүнийг төрөлжүүллээ - БНСУ

Бичил, жижиг дунд бизнес эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих

- ✓ “Миний Монгол-2023” үзэсгэлэн худалдаа - УБ хот, 4 аймаг - 120 гаруй бизнес эрхлэгч хамрагдлаа
- ✓ ЖДҮГ, аймаг дүүргийн ХХҮХ, Хөгжлийн шийдэл ТББ-Бэст хөтөлбөртэй хамтран сургалт, зөвлөгөө - УБ хот болон 21 аймаг -5631 бичил, жижиг бизнес эрхлэгч болон харилцагч хамрагдлаа

Зах зээлээ тэлэх, салбар нэгжийг оновчтой зохион байгуулах

- ✓ 1189 Пос төхөөрөмж гүйлгээнд нэмлээ.
- ✓ Хан-Уул дүүрэгт Шинэ яармаг тооцооны төв нээгдлээ
- ✓ “Эрүүл иргэн-БНСУ” хадгаламжийг төрөлжүүлж БНСУ 2 эмнэлэгтэй хамтын ажиллагааг эхлүүллээ

Олон нийтэд нээлттэй хувьцаат компани болох үүргийн хэрэгжилтийг хангах

- ✓ “Компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлэх хөтөлбөр” “Хувьцаа эзэмшигч, олон нийтэд "Төрийн банк" ХК-ийн мэдээллийг ил тод мэдээлэх, тайлагнах журам” батлагдан мөрдөн ажиллаж байна.

Санхүүгийн боловсрол, зөвлөгөө мэдээлэл хүргэх арга хэмжээг хэрэгжүүлэх

- ✓ “Санхүүч тагтаа” болон Дэлхийн мөнгөний өдөр-2023 аянд нэгдэн 46.0 мянга гаруй оюутан, сурагчдад санхүүгийн боловсрол олголоо
- ✓ “Амжилтын түүх” цуврал 3 контент гаргаж олон нийтэд түгээлээ.
- ✓ 266 байгууллага- 25,732 ажилтан албан хаагчид сургалт мэдээлэл өгч, бүтээгдэхүүн үйлчилгээг борлууллаа
- ✓ Залууст зориулсан санхүүгийн боловсрол, зөвлөгөө, мэдээлэл өгөх 10 цуврал контент бэлтгэн хүргэлээ /Visa Int’l worldwide/

Тогтвортой хөгжлийн хүрээнд баримтлах бодлого, журам, бүтэц



Банк нь БОНЗ-ийн чиглэлийн үйл ажиллагааг өргөн цар хүрээнд хэрэгжүүлэх зорилгоор бүтэц зохион байгуулалтдаа өөрчлөлт оруулж Тогтвортой хөгжлийн албыг үүсгэн байгуулсан.

“Тогтвортой хөгжлийн журам”-ыг баталсан ба уг журмын зорилго нь банкны “Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого”-д заасан тогтвортой хөгжлийн зарчмуудыг банкны бизнесийн болон дотоод үйл ажиллагаанд хэрэгжүүлэх, үр дүнтэй зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавихад оршино.

Тогтвортой хөгжилд чиглэсэн үйл ажиллагаа



Дулаан Шийдэл-2 төслийн хүрээнд хамтран ажиллах санамж байгуулав.

Европын Холбооны Свич Эшиа II хөтөлбөрийн санхүүжилттэй Дулаан Шийдэл-2 төсөлийн хүрээнд Жерес Олон Улсын төрийн бус байгууллага болон Монголын ногоон санхүүгийн корпорацитай Хамтран ажиллах санамж байгуулав. Уг төсөл нь хувийн сууцны эрчим хүчний хэмнэлтийг нэмэгдүүлж, түлшний хэрэглээ, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилготой.



НҮБ-ын Даян дэлхийн гэрээнд гишүүн байгууллага боллоо.

Нийгэмд эерэг нөлөө үзүүлэх, үйл ажиллагаагаа Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тогтвортой байдлын зарчмуудтай уялдуулах зорилгоор НҮБ-ын Даян дэлхийн гэрээнд гишүүн байгууллага болж нэгдлээ.



Нүүрстөрөгчийн нягтлан бодох бүртгэлийн түншлэлд (PCAF) гишүүн боллоо.

Банкны зээл, хөрөнгө оруулалттай холбоотой хүлэмжийн хийн ялгаруулалтыг үнэлж, ил тод болгох, бууруулах зорилгоор Нидерланд улсын нүүрстөрөгчийн нягтлан бодох бүртгэлийн түншлэлд (PCAF) гишүүнээр элсэн орлоо.



“Тогтвортой хөдөө аж ахуйг санхүүжүүлэх” салбар хуралдаан зохион байгуулав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан “Тогтвортой санхүүжилтийн долоо хоног 2023” арга хэмжээнд ТоС Холбоотой хамтран “Тогтвортой хөдөө аж ахуйг санхүүжүүлэх” салбар хуралдааныг амжилттай зохион байгууллаа.



Тогтвортой хөгжлийн тайлан хэвлүүлээ.

Банкны харилцагч, хөрөнгө оруулагч бусад оролцогч талуудад банкны тогтвортой хөгжлийн чиглэлийн үйл ажиллагааг таниулан мэдээлэл хүргүүлэх зорилгоор анх удаа. Тогтвортой хөгжлийн тайлан хэвлүүлээ.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД ДАРААХ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮДИЙГ ДЭМЖИЖ АЖИЛЛАЛАА



БҮХ НИЙТЭЭР МОД ТАРИХ ҮНДЭСНИЙ ӨДӨРТ ТӨРИЙН БАНК НЭГДЛЭЭ

- Төрийн банк нь Ерөнхийлөгчийн санаачилгаар жил бүр зохион байгуулдаг “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийг дэмжин нийгмийн хариуцлагын хүрээнд “Модыг мод(а) болгоё-Ажилтан бүр нэг мод” аяныг 2023.05.13-ны өдрөөс 2023.05.29-ний өдрийг дуустал хугацаанд зарласан бөгөөд аяны хүрээнд нийт 32 нэр төрлийн 4265 ширхэг мод тарьсан байна.

“ГЯЛС ЦЭВЭРЛЭГЭЭ”

- Нийгмийн хариуцлагын хүрээнд “Байгальд ээлтэй Гялс цэвэрлэгээ-2023” аяныг 2023.05.06-ны өдөр Монгол орон даяар 21 аймгийн 315 суманд Төрийн банкны нийт ажилтнууды оролцуулан зохион байгууллаа. Аяны хүрээнд тухайн аймаг, сумын гол горхи, ундны усны ай сав газар нийт 7,440 га талбайг цэвэрлэж, 800 тонн буюу нийт 420 орчим автомашин хог хаягдлыг хог хаягдлыг цэвэрлэж эх дэлхийдээ өөрсдийн хувь нэмрийг оруулав.

ЗӨВЛӨМЖ, МЭДЭЭЛЭЛ

- Нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Цаг уур, орчны шинжилгээний газартай хамтран ажиллах 02a/270 тоот гэрээний дагуу харилцагчдаа цаг агаарын болзошгүй тохиолдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор Гялсбанк аппликейшны мэдэгдэл хэсгээр нийт 52 удаагийн мэдээлэл хүргүүлж ажилласан.



▶ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Хувьцаа эзэмшигчид	Эзэмшлийн хувь
Сангийн яам	49.26%
Хадгаламжийн даатгалын корпораци	45.03%
Олон нийт	5.71%

▶ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

2023 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 95 хувийн ирцтэйгээр хүчин төгөлдөр зохион байгууллаа.

Thank
You



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА